

**МОНГОЛЫН НАМУУДЫН ҮҮРГИЙН ӨСӨЛТ, АРДЧИЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙН  
ХАРИЛЦАН ХАМААРАЛ: ОНОЛ, АСУУДАЛ****Д.Болд-Эрдэнэ** доктор, профессорФСЭЗХ-ийн Улс төр судлалын секторын эрдэм  
шинжилгээний ахлах ажилтан

**Түлхүүр үг:** улс төрийн нам, намын чиг үүрэг, улс төрийн өөрчлөлт, улс төрийн орчин, ардчиллын хэв загвар, ардчилсан шилжилт, ардчиллын нягтрал, ардчиллын чанар, олонхийн ардчилал, зөвшлийн ардчилал, сонгуульт ардчилал, төрийн засаглалын хэлбэр.

**Товч агуулга:** Орчин үед улс төрийн намын нийгэмд гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж буй нь бодитой хандлага юм. Улс төрийн шинжлэх ухаанд намын үүргийн өсөлтөнд нөлөөлж буй хүчин зүйлсийг ерөнхий болон тусгай/ тодорхой / гэсэн хоёр үндсэн түвшинд авч үздэг. Ерөнхий түвшинд намын үүргийн өсөлтөнд нөлөөлж буй үндсэн хүчин зүйл нь улс төрийн орчин, ардчиллын хэв загварын өөрчлөлт, төрийн засаглалын хэлбэрийн төгөлдөржих үйл явцтай холбогддог.

**Намуудын үүргийн өсөлтийн тухайд**

Улс төрч, судлаачдын маргаан хэлэлцүүлгийн гол сэдэв нь намын асуудал байсан, одоо ч тийм байна. Энэ маргаан гол төлөв улс төрийн намын нийгэмд эзлэх байр суурь үүргийн асуудлыг тойрон өрнөдөг нь маргаангүй. Харин олон арван жилийн турш үргэлжилсэн маргаан мэтгэлцээний дүнд ардчилал нь хичнээн ч олон янзын идеаль хэв маяг, бодит загваруудтай байлаа ч эцсийн бүлэгт орчин үеийн ардчилалд намын гүйцэтгэх үүрэг онцгой хэвээр байгааг Өрнөдийн томоохон судлаачид хүлээн зөвшөөрөх болсон нь санамсаргүй хэрэг биш билээ.<sup>41</sup> Үүнтэй холбогдуулан Ричард Катц улс төрийн нам бол либерал ардчиллын үр дагавар мөн гэдгийг онцлоод " орчин үеийн ардчилал бол намын ардчилал" хэмээн дүгнэн бичсэн байдаг.<sup>42</sup> Түүнчлэн Америкийн судлаач С.Элдерсвелд намыг " орчин үеийн нийгмийн улс төрийн гол бүтэц" хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг.<sup>43</sup> Тэгэхдээ ингэлээ гээд өнөө үед намуудыг тойрсон хурц маргаан зогчихоогүй харин ч энэ нь цаашдаа сэдвийн өргөн хүрээг хамран шинэ байдлаар өрнөж, дээрх судлаачдын санааг сөргүүлсэн янз бүрийн дүгнэлт үндэслэлүүдийг гаргах болсон байна.<sup>44</sup> Энэ

<sup>41</sup> Жозэф А. Шумпетер " Капитализм, социализм, ба ардчилал", Р. Даль " Ардчилал ба түүний шүүмжлэл", " Ардчиллын тухай", Лэрри Даймонд " Ардчиллыг хөгжүүлэхүй", Richard S.Katz and Peter Mair ( 1995 ), "Changing Modes of Party Organization and Party Democracy: The Emergence of the Cartel Party, in Party Politics, 1, ( 1995 ): 5-28. "

<sup>42</sup> Katz, R.A Theory of Parties and Electoral Systems, Baltimore: Johns Hopkins University Press.1980.

<sup>43</sup> Eldersveld. S. Political Parties in American Society. N.Y, 1982.p.1

<sup>44</sup> Фрэнсис Фукуяма "Түүх дахин эхлэх үү?", Филипп К. Шмиттер " Ардчиллын зөрчлүүд ба түүнд учирч буй аюул". А.И. Ковлер. "Кризис демократии? \ Демократия на рубеже XXI века \ М.,1997. Холодковский. К.Г "Партии: кризис и закат". "Политические институты на рубеже тысячелетий. ( XX-XXI в) М., 2001



нь бүх эрх мэдэл, бүх санаачлагыг гагцхүү нам гартаа авч, бүх зүйлийг намын хэмжүүрээр авч үзэх нь орчин үеийн ардчиллын гол сул тал мөн хэмээн үзэж буй тэдний байр сууриар илэрдэг.

Сүүлийн үед “улс төрийн намын хямрал”-ын тухай сэдэв өргөн яригдах болсон. Энэ нь орчин үеийн улс төрийн намуудын хөгжилд гарсан өөрчлөлт хувьсал, болон Өрнөдийн либерал ардчиллыг өргөн шүүмжлэх болсонтой холбоотой. Гэсэн хэдий ч орчин үеийн улс төрийн хөгжил, засгийн эрхийн төлөө шударга өрсөлдөөн, улс төрийн хүчнүүдийн олон ургальч байдалд суурилсан улс төрийн ардчилал нь зах зээлийн эдийн засгийн нэгэн адил өнөөгийн ертөнцийн тулгуур үнэт зүйлсийн нэг болох нь улам бүр тодорсоор байгаа билээ. Үүнтэй уялдан 90-ээд оны оны эхээр намын талаарх судалгаа мэдэгдэхүйц сэргэн идэвхжсэн. Энэ нь улс төр дэх намын нөлөө үүргийг үгүйсгэсэн хандлагад хариу болж, улс төрийн намууд мөхөөгүй, харин ч тэд шинэ нөхцөл байдалд дасч зохицсон төдийгүй улс төрийн үйл явц дахь тэргүүлэгч байр сууриа алдаагүй гэдгийг харуулж байна. Өнөө үед улс төрчдийн хэн нь ч орчин үеийн ардчилал дахь намын оролцоог үгүйсгээгүй. Харин ч төрийн ардчилсан тогтолцоог бүрдүүлэх, парламентийн ардчиллыг бэхжүүлэх, бүх нийтийн сонгуулийн эрхийг баталгаажуулах, нийгэмд улс төрийн плюрализмыг цэцэглүүлэх, нийгмийн хөгжлийн бодлогын альтернативуудыг илрүүлэхэд улс төрийн намын гүйцэтгэх үүрэг буураагүй байна.<sup>45</sup>

#### Намын үүргийн өсөлтөнд нөлөөлж буй хүчин зүйлс

Улс төрийн намын нийгэмд гүйцэтгэх чиг үүрэг улам бүр өсөж буй нь бодитой хандлага юм. Үүнийг улс төрч, судлаачид ч нэгэнтээ хүлээн зөвшөөрч байна. Монголын нийгэмд намуудын гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдсээр байгаа нь дээрх бодит хандлагын илрэл гэж үзэх бүрэн үндэстэй.

Улс төрийн шинжлэх ухаанд намуудын нийгэмд гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэх жам ёсны үйл явцыг ерөнхий хийгээд тусгай /тодорхой / учир шалтгаантай холбон тайлбарладаг. Ерөнхий түвшинд Монголын намуудын үүргийн өсөлтийн үйл явцыг дараах бодит шалтгаан нөхцөлтэй холбон үзэж болох байна. Энэ нь **нэгдүгээрт** Монголын өнөөгийн ардчилсан өөрчлөлтийн үйл явцыг улам гүнзгийрүүлэх, ардчиллыг нягтруулах шаардлагатай, **хоёрдугаарт** ардчиллын улс төрийн орчин, оршин үйлчилж буй ардчиллын хэв загварыг боловсоронгуй болгох хэрэгцээтэй, **гуравдугаарт** төрийн шинэ байгууламж, ардчилсан засаглалын хэлбэрийг төгөлдөржүүлэх, түүний эрх зүйн үндсийг чадавхжуулах шаардлага өсөх болсон зэрэгтэй холбоотой юм.

Нийгмийн улс төрийн амьдрал нь түүнийг бүрдүүлж байгаа институт, байгууллагууд болон хүмүүсийн улс төрийн оролцоо, үйл ажиллагаагаар тодруулж хэлбэл **нийгмийн улс төрийн тодорхой өөрчлөлтөөр** дамжин хэрэгжих амьд эрч хөдөлтэй үйл явц мөн. Ардчилсан өөрчлөлтийг гүнзгийрүүлэх, ардчиллыг нягтруулан чанаржуулах үйл явцыг гардан хэрэгжүүлж, гүйцэлдүүлэх улс төрийн хамгийн идэвхтэй институт бол намууд гэдэгтэй хэн ч маргахгүй. Улс төрийн шинжлэх ухааны ном бүтээлд “улс төрийн ардчилсан тогтолцоо, орчин”-ны

<sup>45</sup> Ш.Содном. “Улс төрийн намуудын бүтэц, зохион байгуулалтын төлөв хандлага” Чөлөөт сэтгэлгээ. 2008 № 02 \ 11\, 30 тал.



функциональ илэрхийлэл нь улс төрийн ардчилсан өөрчлөлтийн үйл явц мөн гэж тэмдэглэсэн байдаг<sup>46</sup> нь санамсаргүй хэрэг бишээ.

Сүүлийн үед орчин үеийн Өрнөдийн томоохон улс төрийн шинжээчид дэлхийн улс орнуудын хүрээнд хийгдэж буй ардчилсан өөрчлөлтийн үйл явцыг дотоод агуулгаар нь өөрчлөлтийн хэд хэдэн онцлог үеүүдэд зааглан харьцуулж, дүн шинжилгээ хийх болсон. Үүнтэй холбогдуулан "Азийн Барометр" судалгааны хүрээн дэх "Зүүн Ази дахь ардчиллын чанар ба дэглэмийн легитим чанар"-ын судалгааны багийнхны баримжаа болгож буй арга хандлагыг онцлон үзэхэд сонирхолтой байна. Тэдний үзэж байгаагаар "сүүлийн 20 жилийн турш ардчилсан шилжилт, ардчиллын нягтрал, ардчиллын чанар гэсэн гурван ойлголтын дагуу дэлхий дэх улс төрийн өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж ирсэн." байна<sup>47</sup>. Энэ үүднээс үзвэл Монголын өнөөгийн ардчилсан өөрчлөлтийн үйл явцыг тэдний санал болгосон ардчилсан шилжилт; ардчиллын нягтрал; ардчиллын чанар гэсэн агуулгаар шинжлэн үзэх нь зохистой хэмээн үзэж буй болно.

Ардчилал өндөр хөгжсөн, өөрчлөлтийн олон зуун жилийн туршлага бүхий ихэнх улс орнуудын хувьд ардчиллын шилжилт буюу ардчилалтай танилцах, ардчиллыг нягтруулах замналыг хэдийнээ туулж бараад одоо энэ үндсэн дээр түүнийг чанаржуулах зорилтыг шийдвэрлэж буй нь тэдгээр улс орнуудын хувьд нийтлэг хандлага болж байна. Харин ардчиллын замаар замнаад төдий л удаагүй, посткоммунист манайх шиг улс орнуудын хувьд ардчилсан өөрчлөлтийн үйл явцын өрнөлт цаг хугацаа, туулсан замнал нь харилцан адилгүй, ялгаа бүхий байгааг онцлох хэрэгтэй. Тэдгээр улс орнуудын зарим нь ардчилалтай танилцахаас нягтруулах үед шилжих зурвас үед байхад нөгөө хэсэг нь ардчиллыг нягтруулах төвөгтэй зорилтуудыг шийдвэрлэж эхлээд байна. Үүнтэй холбогдон тэдгээр улс орнуудын ардчиллын замналын асуудал маргаан хэлэлцүүлгийн том сэдэв болсоор байна.

Монголын ард түмэн өнгөрсөн зууны 80-90-ээд оны зааг үеэс ардчиллыг хөгжлийн гол зам гэж үзээд эргэлт буцалтгүй сонгосон. Монгол орон өнөөдөр хүн төрөлхтний нийтээр хүлээн зөвшөөрсөн ардчиллын үнэт зүйлст суурилсан өөрчлөлтийг хийж байна. Өнгөрсөн 90 оны дунд үетэй харьцуулахад ардчилал нь үзэл санаа, оргилуун хүсэл зоригоос халин гүнзгийрч, олон түмний аж байдал, үйл хэрэг амьдралын хэрэгцээний түвшинд очжээ. Монгол улс ардчилсан өөрчлөлтийн үйл явцад шилжсэнээс хойших хорь орчим жилийн хугацаанд манай ард түмэн ардчилсан өөрчлөлтийн гарааны баттай суурь үндсийг бүрдүүлж, нийгмээ ардчилсан нээлттэй зарчмын дагуу шинэчлэн өөрчлөх зүй ёсны үйл явцын эхлэлийг тавьж чадсан. Хүний эрх чөлөөний тулгуур зарчмуудыг эрх зүйн хувьд баталгаажуулж, ардчилсан төрийн байгууламжийн бүтцийн үндсийг бүрдүүлэн олон намын тогтолцоог хэлбэршүүлж, нийгмийн ухамсрын хүрээнд сэтгэлгээний догматизмаас чөлөөт, прагматик сэтгэлгээний хэлбэрт баттай шилжин, улс орныхоо ардчилсан өөрчлөлтийн материаллаг болон оюун санааны суурь үндсийг бүрдүүлж чадсан нь бидний өнгөрсөн хорь орчим жилийн үйл ажиллагааны гол ололт мөн.

<sup>46</sup> Bell Daniel A. 2006. *Beyond Liberal Democracy*. Princeton University Press, 2006; Bell Daniel, D.Brown, K.Jayasuriya and D.Jones, 1995.eds. *Towards Liberal Democracy in Pacific Asia*. New York: St.Martin's Press; Chu Yun-han. 2006. "Third Wave Democratization in East Asia: Challenges and Prospect, ASIEN 100;11-17; Compton, Robert.2000 *East Asian Democratization: Impact of Globalization, Culture, and Economy*. New York: Praeger; Diamond Larry. 2008. *The Spirits of Democracy*. New York: Henry Holt.

<sup>47</sup> "Азийн Барометр: Зүүн Ази дахь ардчиллын чанар ба дэглэмийн легитим чанар" УБ.,2008, 50 дахь тал.



Хэдий тийм боловч Монголын ардчиллын одоогийн олсон амжилт, ололт бүхэн өнөөгийн ардчилалд зайлшгүй хэрэгтэй түүний суурь нөхцөл болохоос биш ардчиллын төлөвшилтийн төгс хэмжүүр баталгаа нь хараахан болж чадахгүй юм. 2006-2008 онд хийгдсэн "Азийн барометр" судалгааны хоёр дахь шатанд оролцсон судлаачдын байр суурь сонирхол татаж байна. Тэдний үзэж байгаагаар "Зүүн Азийн ардчиллын гурав дахь давалгаанд дэлгэрэнгүй, динамик шинжилгээ хийхдээ бид ардчилах үйл явцыг зөвхөн төлөөллийн байгууллагуудыг бий болгох, ардчилсан Үндсэн хуулийг батлах зэргээр тогтохооргүйгээр олон талт үзэгдэл гэж ойлгож байна"<sup>48</sup> гэсэн нь анхааруштай юм. Үүнтэй холбогдуулан судлаач Роуз бичихдээ посткоммунист улс орнуудын ардчилсан өөрчлөлтийн хүрээнд бий болгосон болон бий болж буй зарим нэг нааштай суурь эхлэл институциональ үндэс нь үнэн хэрэгтэй тэдгээр улсуудын хувьд төлөөллийн ардчиллын "техник хангамж" төдий л зүйл болохоос бус "программ хангамж" нь болж чадахгүй байгаа юм.<sup>49</sup>

Монгол орон хэдийгээр 1990 оны дунд үеэс Фрийдом Хаус ( Freedom House) –судалгааны байгууллагын дүгнэлтээр чөлөөт ардчилсан улсын ангилалд багтсан ч ( 1990-1991онд 4.0 оноотой буюу чөлөөт бус, 1991-2002 онуудад 2.5 буюу хагас чөлөөт, 2003 оноос 2.0 буюу чөлөөт ангилалд орсон ) манайд ардчиллын олон үнэт зүйлс хэрэгжиж, төгс бодит агуулгаараа төлөвших болоогүй байна. Өнөөдөр Монголд ардчилал хэлбэр талаасаа бодитой байгаа болохоос бус агуулга талаасаа сайн зүгширч чадаагүй байгаа билээ.<sup>50</sup> Үүний илрэл нь дээрх судалгааны байгууллагаас явуулсан шинэчилсэн судалгаагаар Монгол улс энэ оноос хагас чөлөөт ангилал руу ухрах болсон явдал юм.<sup>51</sup>

Монгол Улсын сонгож авсан ардчилсан хөгжлийн чиг шугамыг иргэд тууштай дэмжиж байгаа дүр зураг\* ШУА-ийн ФСЭХ, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн " Альтернатив" төв, Социологийн тэнхимийн "Социологийн академи", Улс төрийн боловсролын академи, "Прогноз" хүрээлэн, "Сант марал" төв зэрэг байгууллагуудаас хийсэн бараг бүх судалгаанаас гарсан байдаг. Энэ нь монголын ард түмний сэтгэл зүйд ардчиллыг өргөн хүрээнд нягтруулан хөгжүүлэх хүсэл эрмэлзэл баттай бий болсоныг харуулж байна. 1989-1990 онд Монгол Улс ардчилалд шилжсэнийг хүн амын дийлэнх нь зөв \ 80 орчим % \ гэж үзсэн хэвээр байна. Харин ардчиллын үзэл санаа бодит байдалд хэрэгжиж буйн талаархи үнэлгээ үүнээс доогуур буюу 50-60 хувьтай байна.<sup>52</sup> Монголын ардчиллын асуудалд холбогдох хамгийн сүүлийн гэж хэлж болох томоохон судалгаа нь " Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ" \ 2005-2006, 2007-2008, 2009-2011\сэдэвт цогц судалгаа юм. Энэхүү судалгааны дүнгээс олон нийтийн болон шинжээчдийн үнэлгээгээр Монголын ардчилал бодит үзэгдэл болсон хэдий ч бүрэн баталгаажиж, эргэлт буцалтгүй болсон гэхэд эргэлзээ төрөхөөр дүр зураг гарчээ.

<sup>48</sup> "Азийн Барометр: Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа" УБ., 2008, 7 дахь тал.

<sup>49</sup> Дэлхийн санхүүгийн эдийн засгийн хямрал ба Монгол улс. УБ., 2009, 132 дахь талд үзнэ үү.

<sup>50</sup> Д. Болд-Эрдэнэ. "Монгол дахь ардчилсан өөрчлөлтийн онолын зарим асуудал". Философи, эрх зүйн судлал. XXII боть, УБ., 2007

<sup>51</sup> "Монгол хагас эрх чөлөөтэй орны жагсаалтад оржээ" гэсэн бэсрэгхэн нийтлэл мэдээнээс үзнэ үү. "Өдрийн сонин" 2010.01. 14. № 010.

\* Монголчууд социологийн толинд. ШУА-ийн ФСЭХ –ээс Орос, Англи, Монгол хэлээр гаргадаг судалгааны цуврал товхимол. №1 УБ., 1999. №2, УБ., 2001.

<sup>52</sup> Г.Чулуунбаатар. XX, XXI зууны зааг үеийн Монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил. УБ., 2009. 248-249 дахь тал.



Монгол дахь ардчилсан засаглалын төлөв байдлын талаарх ерөнхий үнэлгээ 2008 онд **3,00** оноогоор гарчээ. Энэ нь Монголын ардчилал үндсэндээ 2005 оны үеийхтэй харьцуулахад эерэг өөрчлөлт гараагүй, өөрөөр хэлбэл хаашаа ч эргэж болох эгзэгтэй нөхцөлд хэвээрээ байгаа бөгөөд ерөнхий хандлагын хувьд ухрах шинж ажиглагдсаныг харуулж байна.<sup>53</sup> (Бүдүүвч 1)

**Бүдүүвч 1 Ардчилсан засаглалын төлөв байдал**  
( Шинжээчдийн үнэлгээ )

	Экспертүүдийн үнэлгээний дундаж оноо		Гарсан өөрчлөлт
	2005	2008	
1. Иргэний харьяалал, хууль ба эрх	2.8	3.2	0.4
2. Төлөөлөл бүхий хариуцлагатай засаг төр	2.64	2.8	0.16
3. Иргэний нийгэм ба ард түмний оролцоо	2.84	2.93	0.09
4. Улс орны хилийн чанад дахь ардчилал	3.8	3.7	-0.1
<b>Ардчилсан засаглалын ерөнхий үнэлгээ</b>	<b>3.02</b>	<b>3.0</b>	<b>-0.02</b>

Эх сурвалж: Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт. 2007-2008. УБ., 2008, 123-124 дахь тал.

Харин олон нийтийн үнэлгээнээс үзвэл монгол дахь ардчилсан өөрчлөлтийн шинж байдалд дунд зэрэг гэсэн үнэлгээг өгсөн нь судалгаанаас тодорхой байна. \ Хүснэгт № 2 \

**Бүдүүвч 2. Монголын ардчиллын хөгжил**  
( олон нийтийн үнэлгээ )

Манай оронд ардчилал хэр хөгжиж байна вэ?	
	Хувь
Маш сайн	4.4
Сайн	28.4
Дунд зэрэг	52.9
Муу	10.9
Маш муу	3.4
<b>Бүгд</b>	<b>100.0</b>

Г.Чулуунбаатар.  
“XX, XXI зууны зааг үеийн Монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил” УБ.,2009, 249 дахь тал.

Дээрх хүснэгтүүдээс үзвэл манайд ардчиллыг улам төгөлдөржүүлж бэхжүүлэх хэрэгтэй нь харагдаж байна. Тэгэхдээ энэ үйл явц уламжлалт нийгмийн инерци сэтгэлгээ хүчтэй, ардчиллын туршлага уламжлал гэхээр зүйл байхгүй манайх шиг улс орны хувьд төвөгтэй өвөрмөц байх нь илэрхий.

Монголд өнөөдөр ардчилалтай танилцах “ардчилсан шилжилт”-ийн зорилтуудыг амжилттай шийдвэрлэхийн хэрээр ардчиллыг нягтруулах төвөгтэй

<sup>53</sup> Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт. 2007-2008. УБ., 2008. 122дахь тал.



зорилтыг шийдвэрлэх хэрэгтэй болж байна. Эндээс Монголын ардчиллын замналын агуулга үе шат, онцлогийн тухай асуудал зүй ёсоор гарч ирдэг.

Энэ асуудлын хүрээнд Монголын ардчилал шилжилтийн ардчилал уу? эсвэл шилжилтийн үндсэн зорилтуудыг нэгэнт шийдвэрлэсэний хирээр өрнөж буй төлөвшилтийн ардчилал уу? гэсэн асуудал зүй ёсоор тавигддаг. Ер нь шилжилтийн ардчиллын тухай асуудал онолын хувьд сонирхолтой төдийгүй ихээхэн маргаан дагуулсан асуудал хэвээр байна.<sup>54</sup> Тухайлбал судлаачдын нэг хэсэг нь "шилжилтийн үе" хэмээх нь К.Марксын формацын онолтой холбоотой хуучирсан нэр томъёо гэж үзэж байхад нөгөө хэсэг нь шилжилтийн зурвас үе аливаа өөрчлөлтийн явцад зайлшгүй байдаг, шилжилтийн үе бол бодит процесс хэмээж байгаа юм. Гэвч энэ асуудалд бодитой хариу өгөх нь тийм ч амар хялбар биш. Учир нь Монголын ардчиллын явцад "шилжилтийн үе" гэсэн нэр томъёог хэрэглэх эсэх дээр өнөө ч маргаантай, манай судлаачдын байр суурь нэг мөр болж чадаагүй байна.

Хэдий тийм боловч улс төрийн шинжлэх ухаанд боловсроогүй нийгмийг аажмаар зүгшрүүлэн төгөлдөржүүлж, өрнөж буй үйл явцыг зөв гольдрол чиглэлд нь оруулах бүхэл үйл явцыг "шилжилтийн үе" гэсэн нэр томъёогоор танин мэдэхүйн түвшинд тодотгон хэрэглэдэг. Энэ агуулгаар улс төрийн ном зохиолд "шилжилтийн үе"-ийг шинэ зүйлийн тулгуур үндэс бүрдэх, ардчилсан улс төрийн байгууламж хийгээд ардчилсан үнэт зүйлс, үзэл үнэлэмжийн хэлбэршин зүгшрэх бүхэл үйл явцын үргэлжлэн хэрэгжих зурвас үеийг тэмдэглэсэн ойлголт гэдэг утгаар өргөн хэрэглэдэг.

Шилжилтийн үе дуусаагүй гэсэн байр суурийг илэрхийлдэг судлаачид Монголын ардчиллыг түүний төлөвшиж гүйцээгүй заримдаг шинжүүд тодорхойлж байна<sup>55</sup> хэмээн үздэг бол шилжилтийн зорилтыг шийдвэрлэсэн гэж үздэг талынхан Монголын ардчиллын нэгэнт бүрэлдэж бий болсон институтциональ болон үзэл сэтгэлгээний суурь үндсийн тухай асуудлыг хөндөж тавьдаг юм.

Монголын ардчилал шилжилтийн төвөгтэй цаг үеийн зорилтуудыг шийдвэрлэж дуусах явцад ардчиллыг нягтруулах амаргүй үед аажмаар шилжих завсрын өвөрмөц зурвас үеийн зааг дээр явж байна гэсэн байр суурьтай байна. Тэгэхдээ энэ "шилжилт"-ийг 90-ээд оны эхэн үеийн шинэ зүйлийг бүрдүүлэх шилжилтийн зорилтуудаас нилээд ялгаатай ардчиллыг нэгэнт бий болсон суурин дээр нь бэхжүүлж, төгөлдөржүүлэх, нягтруулахад чиглэсэн өөрчлөлтийн шинэ бөгөөд амаргүй үе буюу "ардчиллыг нягтруулах үеийн гарааны зорилтуудыг шийдвэрлэх үе" хэмээн томъёолон тодорхолж болохоор байгаа юм. Энэ түүхэн зорилтыг хэрэгжүүлэхэд урьдын адил улс төрийн намуудын гүйцэтгэх үүрэг, оролцоо онцгой учир холбогдолтой хэвээр байна. Монголын ардчилсан өөрчлөлтийн үйл явцын дээрх онцлог бүхий нөхцөлд намуудын төлөвшилт түүний үе шатны тухай асуудал сонирхол татах нь зүйн хэрэг.

Монголын улс төр дэх намуудын гүйцэтгэх үүргийн өсөлт нь тус орны **өнөөгийн улс төрийн ерөнхий орчин, оршин үйлчилж буй ардчиллын хэв загварын өөрчлөлтийн төлөв байдалтай** холбоотой байна. Учир нь ардчилсан нийгэмд намууд улс төрийн тодорхой орчин нөхцөлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж төлөвшиж байдаг жамтай. Манай судлаач Ж.Болдбаатар, А.Цанжид нар намууд нийгэм дэх чиг үүргээ бодитой хэрэгжүүлэхийн тулд тэдэнд тодорхой орчин

<sup>54</sup> А.Саруул. "Шилжилтийн үеийн тухай онолын маргаантай асуудлууд". Шинэ толь 2005 № 53.

<sup>55</sup> "Монгол улсын шилжилтийн үеийн улс төрийн намуудын үүрэг" УБ., 2006.



нөхцөл хэрэгтэй байдаг талаар сонирхолтой санааг дэвшүүлсэн байдаг.<sup>56</sup> Ер нь намуудын нийгэмд гүйцэтгэх үүргийн үр нөлөө нь “нийгмийн улс төрийн орчин-улс төрийн тогтолцоо-намын төлөвшил” гэсэн харилцан хамаарал бүхий гурвалсан цогц нөхцөл, хүчин зүйлтэй холбоотой.

Энэхүү гурвал холбоонд нийгмийн улс төр, эрх зүйн ерөнхий орчин нөхцөл чухал учир холбогдолтой байдаг. Учир нь орчин үеийн нийгмийн улс төрийн тогтолцоонд гүйцэтгэх намуудын үүрэг оролцоо нь улс төр, эрх зүйн болон нийгэм-сэтгэл зүйн тодорхой орчин нөхцөлийг зүй ёсоор шаарддаг. Хэдийгээр улс орнуудын улс төрийн намуудын нийгэмд гүйцэтгэх үүрэг ерөнхий агуулгаараа адил төсөөтэй боловч хэрэгжих нөхцөл боломжийн хувьд харилцан адилгүй байдаг. Үүний улмаас намуудын нийгэм, улс төрийн тогтолцоонд гүйцэтгэх үүрэг оролцоо, жин нөлөө нь өөр өөр байдаг. Тиймээс намуудын төлөвшилтийн бодитой бөгөөд зохистой орчин нь нийгэм улс төр, эрх зүйн ардчилсан орчин байдаг бөгөөд харин энэ тохиолдолд нам нь ардчилсан нийгэмд түүний үнэт зүйлсийг хэрэгжүүлэх хамгийн идэвхтэй улс төрийн институт болж байдаг.

Улс төрийн шинжлэх ухаанд “нийгмийн улс төрийн орчин” гэдэг ойлголтыг улс төрийн институт, субъектуудын үйл ажиллагаагаар нөхцөлдсөн улс төрийн ахуйн үзэгдэл, үйл явцын илрэн хэрэгжих тодорхой орон зайн хэлбэр, улс төрийн цогц хүчин зүйлсийн үйлчлэн орших өвөрмөц хүрээ хэмээн томъёолон тодорхойлдог. Түүнээс гадна улс төрийн ном бүтээлд улс төрийн орчинг хэв маягийн хийгээд хэлбэрийн хувьд тодорхой ялган заагласан байдаг бөгөөд хэв маягаар нь ардчилсан ба ардчилсан бус, нээлттэй, хаалттай, хөгжмөл ба хөгжмөл бус, тогтвортой ба тогтворгүй гэх зэргээр ангилдаг бол хэлбэрээр нь улс төрийн институт, байгууллагын, улс төрийн ухамсар, оюун санааны, улс төрийн соёлын болон эрх зүйн улс төрийн үйл байдлын орчин гэх мэтээр тодорхой ялган үздэг.<sup>57</sup>

Тэгэхдээ улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн орчинг нийгмийн ардчилагдсан ба ардчилагдсан бус байдлын түвшингээр хэмжиж үзэх нь түгээмэл бөгөөд энэ агуулгын үүднээс ардчиллын хэв загварын шинж байдлыг нийгмийн улс төрийн ардчилсан орчны гол хэлбэр хэмээн үздэг билээ.

Ардчилсан нийгэмд намууд үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулах боломж бүрэн нээлттэй байдаг. Чухамдаа эл нам хэмээх тогтолцоонд хандах хандлагаар нь улс орнуудын ардчиллын хэв загварыг вестминистерийн буюу олонхийн, консенсусын буюу зөвшилцлийн хэмээн ялгаж үздэг гэж хэлж болох юм. Вестминистерийн буюу олонхийн, консенсусын буюу зөвшилцлийн ардчиллын аль алинд нь улс төрийн намын хүчин зүйл онцгой учир холбогдолтой байдаг ч нийгмийн улс төрийн тогтолцоон дахь тэдний байр суурь, нөлөө оролцоо, гүйцэтгэх үүрэг нь ардчиллын дээрх хэв загварын шинж байдалтай уяалдан өвөрмөц ялгаатай байдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Америкийн судлаач А.Лийпхарт “Ардчиллын хэв загвар” хэмээх бүтээлдээ гучин зургаан орны төр засгийн хэлбэрийг харьцуулан судлаад ардчиллын олонхийн хэв загвар оршин үйлчилж буй улс орнуудын улс төрийн тогтолцоонд хоёр гол нөлөө бүхий намын үүрэг оролцоо хүчтэй байдаг бол зөвшилцлийн ардчиллын нөхцөлд улс төрийн олон намуудын үүрэг оролцоо илүү учир холбогдолтой байдаг

<sup>56</sup> Ж.Болдбаатар, А.Цанжид “Улс төрийн намаас нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг”, Бодрол, бясалгал. 1991 № 8, 36 дахь тал.

<sup>57</sup> М., Э.А. Поздняков. “Улс төрийн философи” УБ., 2005, М.Н. Марченко “Политология” М., 1999, В.В.Ильин. Политология” М., 2000, Д.Болд-Эрдэнэ. “Монголын өнөөгийн улс төрийн орчны төлөвшилтийн зарим асуудал”, “Шинэ толь”, 2003. №43.



тухай дүгнэн бичсэн байдаг.<sup>58</sup> Сонгодог Вестминистерийн загвар бүхий Их Британи, Австрали, Шинэ Зеланд, Канад зэрэг улс орнуудад нөлөө бүхийн хоёр гол нам засгийн эрхийг ээлжлэн барьж, тэр нь парламентын олонхи, гүйцэтгэх эрх мэдлийг зангидан төвлөрүүлж байдаг. Нэг үгээр хэлбэл парламентийн олонхи, Засгийн газар, ялсан намын удирдлага үнэн хэрэгтээ нэг удирдагчийн гарт төвлөрч, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд эрх баригч намын хяналт, оролцоо онцгой нөлөөтэй байдаг. Энэ утгаараа эрх баригч намын бодлого, хөтөлбөр улс орны хөгжлийн гол үндэс болж өгдөг. Тэгвэл зөвшлийн ардчилал бүхий Герман, Дани, Норвег, Голланд зэрэг улс орнуудад зонхилгогч гол намын нөлөө гэхээсээ илүү олон намуудын зөвшлийн механизм улс орны хөгжлийн явцад чухал нөлөөтэй байдаг. Нэг үгээр хэлбэл зөвшлийн ардчиллын нөхцөлд улс төрийн тогтолцоонд оролцох намуудын оролцоо, гүйцэтгэх үүрэг нилээд өргөн дэлгэр шинжтэй байдаг.

Эндээс үзвэл олонхийн ардчиллын нөхцөлд гол нөлөө бүхий намын оролцоо улс төрийн тогтолцоонд зонхилоод зогсохгүй тэрхүү намын эрх мэдэл, гүйцэтгэх үүрэг нь хүчтэй үр нөлөөтэй байдаг бол зөвшлийн ардчиллын нөхцөлд олон намуудын оролцоо улс төрийн системд өргөн байдаг ч нийгэм дэх намын хэт нөлөө дарангуйлалыг зохих түвшинд нь барьж байх бололцоо бүрдмэл байдаг байна.

Ардчиллын хэв загварын энэ онцлогийн тухай судлаач О.Машбат бичихдээ: "...Британд нам хүчтэй хөгжиж, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагыг хяналтандаа оруулсан юм. Ингэж оруулсанаар эл хоёр эрх мэдэл нэг нь нөгөөтэйгээ намын шугамаар уусан нэгдэж хүчирхэг том механизм болж төвлөрчээ. Өөрөөр хэлбэл нам хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг хоёуланг нь атгасан дарангуйлагч болсон байна. Гагцхүү түүнийг ард түмнээс тодорхой хугацаанд сонгодог тул "сонгуульт дарангуйлал" хэмээн нэршжээ. Харин Германы төр засаг түүхээсээ намд төдийлөн итгэлгүй ханддаг байсан бөгөөд намуудын хоорондох улс төрийн тэмцлийг парламентийн хүрээнд хаших механизм тогтоож, ингэснээрээ гүйцэтгэх эрх мэдлийн бие даасан тогтвортой байдлыг хангаж өгсөн юм"<sup>59</sup> гэсэн байна.

Энэ бүхнээс дүгнэж үзвэл улс төрийн тогтолцоон дахь намын оролцоо, үүрэг нийгмийн улс төрийн ерөнхий орчин нөхцөл тэр дундаа оршин үйлчилж буй ардчиллын хэв загварын онцлог байдлаас хамааран өвөрмөц ялгаа бүхий байдаг нь харагдаж байна. Тэгсэн хэдий боловч эцсийн дүндээ улс төр, эрх зүйн орчин нь тогтвортой, харьцангуй төлөвшсөн нөхцөлд улс төрийн намуудын үүрэг оролцоо идэвхтэй үр нөлөөтэй байж чаддаг. Тухайлбал ардчилал нэгэнт тогтворжсон, эрх зүйн зохицуулалтын чадамж өндөр АНУ, Их Британи, Франц, ХБНГУ, Австрали, Шинэ Зеланд гэх зэрэг улс орнуудад намын нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцоо хэвшиж тогтсон үр нөлөө бүхий байдаг бол шинээр ардчилагдаад төдий л удаагүй пост-коммунист шилжилтийн хэв маягийн улс орнуудад намуудын нийгэм дэх оролцоо, гүйцэтгэх үүрэг нь хангалттай бус, бэрхшээл асуудалтай төдийгүй эрх зүйн зохицуулалтын орчин чадамж нь сул байдаг. Үүнийг Зүүн Европ, ЗХУ \ хуучин нэрээр \-ын бүрэлдэхүүнд байсан зарим улс орнууд болон манай улс төрийн намуудын төлөвшилтийн явц туршлагаас тодорхой харж болохоор байдаг.

Манай судлаачид монголын өнөөгийн улс төрийн орчинг үндсэнд нь ардчилсан хэв маягийн хүрээнд хамруулан үзэх тал дээр төдийлөн санал зөрдөггүй боловч тус орны улс төрийн орчны хэв шинжийн тухайд олон янзын байр суурийг

<sup>58</sup> Аренд Лийпхарт. Ардчиллын хэв загвар: \ Гучин зургаан орны төр засгийн хэлбэр ба илрэл\, УБ., 2007.

<sup>59</sup> О.Машбат. Бонноос Вестминстерийн зүг. УБ., 2007. 93 дахь тал.



илэрхийлдэг. Тухайлбал, тэд монголын улс төрийн орчинг хэв шинжийн хувьд “шилжилтийн”, “завсрын”, “хөгжмөл бус”, “харьцангуй төлөвшсөн”, “үндсэндээ төлөвшсөн” гэх зэргээр томъёолон тодорхойлж байдаг.<sup>60</sup> Монголын өнөөгийн улс төрийн орчин нь манай одоогийн ардчилсан өөрчлөлтийн бодит тусгал болж байна. Тиймээс түүний агуулга нь ардчилалд шилжих шилжилтийн хэлбэрээс ардчиллын нэгэнт бий болгосон суурь үндсийг бэхжүүлэх, нягтруулах үед шилжих “өвөрмөц шилжилт”-ийн зурвас үеийн ардчилсан хэв шинж бүхий орчин гэж үзэж болохоор байна. Тэгэхдээ уг орчинг бүрэн төлөвшсөн орчин гэж хараахан үзэхгүй байгаа болно.

Сүүлийн үед ардчиллын олонхийн болон вестминстерийн, зөвшлийн буюу консенсусын сонгодог загваруудын зэрэгцээ ардчиллын олонхийн, цөөнхийн буюу олигархийн, полиарх ардчиллын, “урвуу ардчилал” буюу “хуурамч ардчилал”, “сонгуулийн ардчилал”, “энгийн ардчилал”-ын тухай сэдвүүд яригддаг. Энэ нь өнөөгийн ардчиллын төлөвшилтийн шинж байдал, тулгарч буй бэрхшээл асуудал, хүрсэн түвшин, түүний шинж чанарын байдлаас үүдэлтэй байгаа юм. Манай зарим судлаачид өнөөгийн монгол улс нь ардчиллын хөгжлийн бие даасан загварыг гүйцэд олоогүй байгаа болохоор дээр тэмдэглэсэн олонхийн болон зөвшлийн загварын аль алиныг нь одоогоор манайд хамруулан үзэх боломжгүй юм гэж байхад,<sup>61</sup> нөгөө хэсэг нь монголд өнөөдөр цөөнхийн буюу “олигархын ардчилал”-ын загвар ноёрхож байна гэж байгаа юм.<sup>62</sup> Тэгвэл судлаачдын гурав дахь хэсэг нь монголд өнөөдөр “урвуу” буюу “хуурамч ардчилал” -ын загвар оршин үйлчлэх боллоо гэцгээж байна.<sup>63</sup>

Сүүлийн үед өрнөдийн зарим томоохон судлаачид болох Л.Даймонд, Ж.Шумпетер нар сонгуульт ардчиллын загварын асуудлыг гарган тавьж, түүнийхээ хүрээнд их төлөв шинэ тутам ардчилагдсан улс орнуудыг хамруулан үзжээ.<sup>64</sup> Тиймээс ч манай зарим судлаачид монгол дахь ардчиллын загварыг сонгуульт ардчиллын загварт хамруулан үзэж байна.<sup>65</sup> Сонгуульт ардчиллын загварт манай ардчиллыг хамруулан үзэж байгаа тухайд цаашид судалж, тодруулах зүйл нэлээд байх шиг байна.

Сонгуульт ардчилсан загварын гол агуулга нь олон намын өрсөлдөөнт сонгуулийг ардчиллын үнэт зүйлсэд тооцон үзэж, ардчиллын бусад хэмжүүрийн ач холбогдлыг тодорхой хэмжээгээр бууруулан, олон түмний улс төрийн оролцоог зөвхөн сонгуульд оролцон санал өгөх явдлаар хязгаарлаж, төрийн үйл ажиллагаанд тавих тэдний хяналтыг багасган, шийдвэр гаргах түвшинд тодорхой эрх мэдэл бүхий цөөн хэсэг хүмүүс л онцгой байр суурь эзэлдэгт оршиж байгаа юм. Сонгуульт ардчиллын зарим тодорхой шинжүүд манайд тохирч байдаг ч өнөөгийн монголын

<sup>60</sup> Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2008, 265 тал, Д.Болд-Эрдэнэ. “Монголын өнөөгийн улс төрийн орчны төлөвшилтийн зарим асуудал.” Шинэ толь. 2003. №43

<sup>61</sup> Г.Чулуунбаатар. Шилжилтийн нөхцөл дэх ардчилал, улс төрийн тогтолцооны Монгол хувилбарын тухайд. Шинэ толь. 1994. №2.

<sup>62</sup> Н.Лүндэндорж. Олигархийн дарангуйлалаас ардчилалд хүрэх зам. “Өдрийн сонин”. 2007.1.8. № 005.

<sup>63</sup> Г.Сайнхишиг. Урвуу ардчилал. “Философи, эрх зүйн судлал. XXII боть. 2007, О.Машбат. Ердийн ардчилал. “Өдрийн сонин”. 2006. № 028.

<sup>64</sup> Joseph A.Schumpeter. Capitalism, Socialism and Democracy (New York: Harper and Row, 1976), Larry Diamond. Developing Democracy: Toward Consolidation (Baltimore: Johns Hopkins University Press, 1999.

<sup>65</sup> Д.Ганбат. К вопросу о теории и методологии развития демократии в Монголии. Автореферат работы на соискание ученой степени доктора политических наук ( Ph.D). УБ., 2002. С. 20.



ардчиллыг дан ганц сонгуульт ардчиллын хэлбэр төдийхнөөр үнэлэн үзэх нь учир дутагдалтай юм. Өрсөлдөөнт сонгууль нь ардчиллын чухал хэмжүүрт тооцогддог ч бид бүх зүйлийг сонгуулиар хязгаарлаагүй, ардчиллын үнэт зүйлсийн хүрээнд хүний эрх, шударга ёс, ил тод байдал, олон ургальч үзэл, хууль дээдлэх зарчим, эв нэгдэл, тэгш ёсны үзлийг бас хамруулан үздэг билээ.<sup>66</sup> Үүнийгээ Үндсэн хуулиараа нэгэнтээ баталгаажуулсан билээ.

Монголд өнөөдөр ардчиллын вестминстерийн буюу олонхийн хэв загвар үйлчилж байна гэж болохоор байна. Манай ардчиллын энэ онцлогийг Америкийн нэрт судлаач А.Лийпхарт "Ардчиллын хэв загвар" бүтээлийнхээ Монгол хэвлэлд зориулсан өмнөх үгэндээ тэмдэглэхдээ "...1992 онд батлагдсан ардчилсан Үндсэн хууль нь бүхэлдээ олонхийн загварын үзэл баримтлалд тулгуурлаж, парламент нэг танхимтай болж, сонгууль нь нэг мандат бүхий мажоритар сонгуулийн тогтолцоогоор явагдаж, ялсан нам нь дангаараа засгийн газар бүрдүүлдэг нь хэм хэмжээ болсон байна. Үндсэн хуульд 2002 онд нэмэлт оруулсанаар олонхийн загварын үйлчлэл улам хүчтэй илрэх болжээ. Үндсэн хуулийн тайлбар гарах эрх аль институтэд хамаарах тухай хуулийн хэм хэмжээ тогтоогүй, парламентийн олонхи үндсэн хуульд өөрчлөлт оруулах бүрэн боломжтой, парламентийн гишүүн засгийн газрын гишүүн байх боломжтой, энэ утгаараа гүйцэтгэх засаг парламентдаа нөлөө ихтэй, сонгуулийн мажоритар хэлбэр нь хоёр намын тогтолцоонд хүчтэй нөлөөлсөөр байгаа зэрэг нь олонхийн загвар Монголд үйлчилж байгааг маш тодорхой харуулж байна."<sup>67</sup> хэмээн бичсэн байна. Тэгэхдээ манайд полиархи ардчиллын зарим элемент байгааг үгүйсгэхгүй. Үүнтэй холбоотойгоор манай зарим улс төрчид ардчиллын харьцангуй гэж болох олонхи давамгайлсан зөвшлийн хэлбэр буюу олонхийн болон зөвшлийн хосолмол хэв загвар хэрэгжиж байна гэж үздэг. Тэгэхдээ одоогоор монголд зөвшлийн ардчиллын сонгодог хэлбэр бүрэн утгаараа хараахан оршин үйлчилж чадаагүй байна. Харин цаашдаа монгол дахь ардчиллын тогтворжилтын шинж байдалтай уялдан тус оронд улс төрийн олон ургальч, прагматик үзэлд суурилсан ардчиллын зөвшилцлийн загвар хэрэгжих магадлал илүүтэй харагддаг юм. Гэхдээ Монголд өнөөдөр зөвшлийн ардчиллын нийгэм, улс төр, эрх зүйн болон ухамсар, оюун санааны бодит хөрс суурь бүрэлдэж чадаагүй байна гэсэн баримтлалтай судлаачид ч байдаг. Хэдий тийм боловч олонхийн ардчиллын зарим сул тал тодорхой илэрч буй өнөөгийн нөхцөлд ардчиллын хэв загварыг өөрчлөн боловсронгуй болгож, аажмаар ардчиллын зөвшилцлийн хэв загварыг тус оронд төлөвшүүлэх нь жам ёсны зорилт мөн билээ. Энэ чухал зорилтыг хэрэгжүүлэхэд улс төрийн намуудын үүрэг, оролцоо зүйрлэшгүй их юм.

Улс төрийн тогтолцоон дахь намуудын гүйцэтгэх үүрэг өсөх болсон нь **төрийн шинэ байгууламж, ардчилсан төрийн засаглалын хэлбэрийг төгөлдөржүүлэх** шаардлага тавигдах болсонтой мөн холбоотой байна. Монгол улс 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулиараа төрийн засаглалын парламентын хэлбэрийг үндсэндээ сонгон хэрэгжүүлсэн билээ. Гэвч манай судлаачдын зарим нь тус оронд хагас Ерөнхийлөгчийн, хагас парламентын буюу төрийн засаглалын холимог хэлбэр үйлчилдэг гэж үздэг бол<sup>68</sup> нөгөө хэсэг нь сонгодог парламентын

<sup>66</sup> Д.Болд-Эрдэнэ. Монгол дахь ардчилсан өөрчлөлтийн онолын зарим асуудал. Шинэ толь. 2006. № 56. 35 дахь тал

<sup>67</sup> Арэнд Лийпхарт. Ардчиллын хэв загвар. УБ., 2007. 10-11 дахь тал.

<sup>68</sup> Д.Чулуунжав. Либеральчлал ба ардчиллын нөхцөл дэх Монголын төрийн тогтолцоо, байгууламж, засаглал, үйл ажиллагааны хууль эрх, улс төр, философийн орчин үеийн тулгуур асуудлууд. \1990-2009\, УБ., 2009 болон түүний бусад бүтээлүүд.



засаглалын хэлбэр Монголд нийцэмжгүй байна хэмээж засаглалын Ерөнхийлөгчийн хэлбэрийг бий болгох нь зүйтэй гэсэн санаа үндэслэл дэвшүүлж байдаг.<sup>69</sup> Тэд энэ байр сууриа илэрхийлэхдээ Монголын өнөөгийн ардчилал, парламент ёсны төлөвшил, парламент болон парламент дахь намын тогтолцооны бүрдэл, парламентийн намуудын үйл ажиллагааны хүрээнд ажиглаглагдах болсон зарим нэг гажуудал, асуудал бэрхшээлийг их төлөв иш үндэс болгож байна. Ерөнхийлөгчийн засаглалыг дэмжсэн нийгэм-сэтгэл зүйн уур амьсгал Монголын нийгэмд ямар нэг хэмжээгээр бүрдэж бий болчихоод байгааг ч үгүйсгэх аргагүй.

Гэвч монголын өнөөгийн улс төрийн өөрчлөлтийн төлөв байдлаас үзвэл төрийн засаглалын одоогийн хэлбэрийг яаран солих шаардлага бага бөгөөд харин тус орны өнөөгийн төрийн байгууламжийн хүрээнд бугшин хуримтлагдах болсон гажуудал, хүндрэлтэй асуудлыг зохистой байдлаар шийдэж, парламентийн засаглалын одоогийн хэлбэрийн нөөц чадамж, далд боломжийг бүрэн дүүрэн илрүүлэн ашиглахад түлхэц болохуйц улс, эрх зүйн зүйн шинэлэг бөгөөд үр нөлөөтэй орчин механизмыг бодитой бүрдүүлэхэд анхаарах нь юу юунаас илүү чухал билээ. Ингэж төрийн байгууламжийн одоогийн хэлбэрийн хүрээн дэх хүндрэлтэй асуудал бэрхшээлийг шийдвэрлэж, парламентийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэхэд улс төрийн намуудын үүрэг, оролцоо асар их юм. Тухайлбал парламентийн олонхи, цөөнхийн харилцаа тэдгээрийн үйл ажиллагааны зохистой хэлбэрүүдийг зүгшрүүлэх, парламент дахь намуудын статус, нөлөө үүргийг тодорхой үр нөлөөтэй болгох, парламентийн гишүүдийн ёс зүйн хэм хэмжээг хуульчлах, гүйцэтгэх засаглал дахь нам, эвслийн оролцоог төгөлдөржүүлэхэд чиглэсэн улс төр, эрх зүйн цогц бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд одоо үйл ажиллагаа явуулж буй улс төрийн намууд болон тэр дундаа парламент дахь намуудын идэвхтэй санаачлагатай үйл ажиллагаа туйлын чухал байгаа юм.

### Abstract

At present the role of political parties in society is significantly increasing. In political science the raise of role of political parties is explaining by causative connection of general and specific factors. In the case of our country the increasing role of political factors is related to impact of following general factors.

Firstly, the process of democratic changes in Mongolia deepens;

Secondly, changes of democratic model affects democratic political environment;

Thirdly, there is an acute need for advanced political governance.

### Ашигласан ном, материал

1. Монголын ардчиллын төлөвшил / Ред: Г.Чулуунбаатар, Д.Болд-Эрдэнэ / УБ., 2011
2. Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2008
3. Азийн Барометр: Зүүн Ази дахь ардчиллын чанар ба дэглэмийн легитим чанар. УБ., 2008

<sup>69</sup> Н.Лүндэндорж. "Олонхийн дарангуйлал" Өдрийн сонин. 2006. №172, "Олигархийн дарангуйлалаас ардчилалд хүрэх зам. Өдрийн сонин. 2007.1.8 № 005.



4. Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт. / 2007-2008 / УБ., 2008.
5. Аренд Лийпхарт. Ардчиллын хэв загвар. / Гучин зургаан орны төр засгийн хэлбэр ба илрэл / УБ., 2007.
6. Э.А. Поздняков. "Улс төрийн философи" УБ., 2005,
7. А.И. Ковлер. "Кризис демократии? \ Демократия на рубеже XXI века \ М.,1997.
8. Холодковский. К.Г "Партии: кризис и закат". "Политические институты на рубеже тысячелетий. ( XX-XXI в) М., 2001
9. М.Н. Марченко. Политология. М., 1999
10. В.В. Ильин. Политология. М., 2000.
11. Ш.Содном. Улс төрийн намуудын бүтэц, зохион байгуулалтын төлөв хандлага. Чөлөөт сэтгэлгээ. 2008 № 02 \ 11\ .
12. Г.Чулуунбаатар. XX, XXI зууны зааг үеийн Монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил. УБ., 2009.
13. Г.Чулуунбаатар. Шилжилтийн нөхцөл дэх ардчилал, улс төрийн тогтолцооны Монгол хувилбарын тухайд. Шинэ толь 1994. №2
14. Н.Лүндэндорж. Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал. УБ., 2010.
15. Д.Ганбат. К вопроу о теории и методологии развития демократии в Монголии. Автореферат работы на соискание ученой степени доктора политических наук ( Ph.D ). УБ., 2002
16. О.Машбат. Бонноос Вестминстерийн зүг. УБ., 2007.
17. Д.Болд-Эрдэнэ. Монгол дахь ардчилсан өөрчлөлтийн онолын зарим асуудал. Философи, эрх зүйн судлал. XXII боть, УБ., 2007
18. Д.Болд-Эрдэнэ. Монголын ардчиллын парадокс. Шинэ толь. 2006. № 57.
19. Д.Болд-Эрдэнэ. "Монголын өнөөгийн улс төрийн орчны төлөвшилтийн зарим асуудал." Шинэ толь. 2003. №43